

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө олгосон зөвшөөрөл болон ойн нөөцийг ашиглах, эзэмших гэрээ нь тухайн зөвшөөрөл, гэрээнд заасан хугацаа дуустал хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2 дугаар зүйл. Ойн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө баталсан ойн менежментийн төлөвлөгөөг уг хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 2 жилийн дотор шинэчлэн батална.

3 дугаар зүйл. Ойн тухай хуулийн 48 зүйлийн 48.1-д заасан Ойн цахим мэдээллийн системийг хөгжүүлэх, хэвийн ажиллах нөхцөлийг хангах, төрийн албан хаагчдыг сургах, нийтэд таниулах, сурталчлах ажлыг хууль 2027 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийг хүртлэх хугацаанд хийнэ.

4 дүгээр зүйл. Ойн анги, сум дундын ойн ангийг Ойн тухай хууль батлагдсан өдрөөс хойш 1 жилийн дотор өөрчлөн зохион байгуулж, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг ... оны улсын/орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Ойн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.3.28 дахь заалт нэмсүгэй:

"5.3.29. Ойжуулалтын сан."

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн "Улсын авто замын сан," гэсний дараа "Ойжуулалтын сан," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 2 зүйлд дор дурдсан агуулга бүхий 3 дах хэсэг нэмсүгэй.

192 дугаар зүйлийн 3 дах хэсэг:

3.Ой, мод, сөөгтэй холбогдсон харилцааг Ойн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тариалангийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт тус тус нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"3.1.8. “агро-ойн аж ахуй” гэж Ойн тухай хуулийн 4.1.23-т заасныг."

2/ 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“16.3. Энэ хуулийн 16.2-т заасан таримлын үйлдвэрлэлийг мод, сөөгийн тариалалттай зориудаар хослуулан агро-ойн аж ахуй эрхэлж болно.”

2 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “...тариалангийн болон ...” гэсний өмнө “агро-ойн аж ахуй” гэж, 19 дүгээр зүйлийн 19.5 дах хэсгийн “... ойн зурвас байгуулах” гэсний дараа “, агро-ойн аж ахуй эрхлэх” гэж, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “ойн зурвас” гэсний өмнө “агро-ойн аж ахуй эрхлэх,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн дугаарыг “16.4” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр баталсан Ойн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ